

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭНЭТЭМНИЙН УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь

Дэд профессор Б. Ралгаа /МУИС/

Түүхийн сурвалж бичигт, бурханы шашныг судалсан судлаачдын ном зохиолоос үзэхэд шарын шашин бол бурханы шашны нэгэн урсгал юм. Өөрөөр хэлбэл, буддагийн шашин МЭӨ VI зууны вед орлогоос 2500 жилийн цаана эртний Энэтхэг оронд үүсчээ. Тэр цагт Энэтхэг оронд боолчлол хүчтэй хөгжиж, ядуучуудын амьдрал нэн хүнд бэрх байсан байна. Дарлагдсан ядуучууд өөрсдийн мөлжигдөн зовж байгаагийн үнэн мөн чанар, учир шалтгааныг тайлбарлаж мэдэхгүй бурхан, сүнс, далдын хүчин зүйлтэй холбон үздэг байв.

В. И. Ленин “Зэрлэг хүмүүс байгальтай тэмцэх тэмцэлд хүчин мөхөсдөхөд бурхан чөтгөр, ид шидтэнг бишрэх итгэл төрдөгийн адил дарлагдсан анги дарлагчдын эсрэг тэмцсэн тэмцэлд хүчин мөхөсдөхөд хойд насандаа сайн төрөл олж төрөх итгэл зайлшгүй төрдөг юм.”¹ гэжээ.

Яг ийм түүхийн нөхцөлд Буддагийн номлол дэлгэрч байснаараа хүн ардын нилээд хэсгийн сонирхол татаж, тэдний дотор улам нэвтрэх хандлагатай болжээ. Гэхдээ бурхны шашныг үндэслэгчид нь өөрийн энэхүү нөлөөгөө улам өргөжүүлэх үүднээс “Зовлон гачаал, хүнд бэрх байдал” нь бүх хүмүүст адил тэгш хэмээн зарлаад, энэхүү зовлонгийн шалтгаан бол нийгмийн буруугаас бус хувь хүмүүсийн өөрийн нь талаас шалтгаалдаг гэж итгүүлэхийг чиглэж байсан бол, тэр вед оршин байсан нийгмийн харилцааны эсрэг шинж чанарыг хадгалж байсан.

Ийм ч учраас тухайн вед дарлагдсан олон түмний сонирхлыг илэрхийлсэн шашны шинэ урсгал болж дэлгэрэх үндэс нь болсон юм. Харин бурханы шашин бий болсон өвөрмөц талыг гаргахдаа эхнээсээ ноёрхогч ангийн зэвсэг болж байсан, түүний харгис шинж чанарыг нэгэн адил дүгнэж үзэхийн хамт нөгөө талаар бурханы шашны энэрэнгүй хүнлэг бүх хүн ардын сайн сайхны төлөө чиглэсэн үзэл санааг ч бас нэгэн адил авч үзвэл зохилтой юм.

Бурханы шашин нь хүмүүсийг зовлонгоос хагацах арга, зам мөрийг номлохдоо тухайн нийгмийн байгуулалттай тэмцэх замаар бус гагцхүү ухаан зарж, зовлон хүн бүхэнд адил тэгш гэдэг дээр тулгуурлан нийгмийн гол ёс суртахууныг зөвхөн сайжруулж байж болох зүйл хэмээн үздэг байв.

Чухамхүү ийм номлолыг ангит нийгмийн үндсэн зэвсэг мөн гэдгийг боол эзэмшигч нийгмийн ноёлогч ангийн зүгээс харахгүй байж чадаагүй. Ийм ч учраас эртний Энэтхэгийн боол эзэмшигчид удалгүй бурханы шашныг юуны өмнө олон түмнийг хүлцэнгүй номхоноор барьж байх зэвсэг, нөгөө талаар Бархманы номлолыг нухчин дарах үндсэн зэвсэг хэмээн үзэж өөрийн үзэл санааны тулгуур болгон хүлээж авсан байна.

Гаутам Сиддхара бурханы уламжлалт ёсонд уул шашны үндэслэгч нь Гаутам овгийн Сиддхара хэмээх гэгчийг үздэг бөгөөд хожим алдарт их соён гийгүүлэгч, номлогч, энэрэнгүй үзэлтэн гэж бурханы шашинтны дотор алдаршжээ.

Гаутам Сиддхара нь бурханы номлолын аль нэг урсгалыг үндэслэгчийн нэг болсон нь тодорхой боловч харин бурханы шашны бүхэл бүтэн системийг бүтээсэн хүн гэж үзэж болохгүй, тухайн нийгмийн түүхчдийн, сүсэгтний хамт олны оюуны бүтээл болох нь мэдээж билээ.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Өөрөөр хэлбэл бурханы номлол нь тухайн вөд оршин байсан нийгмийн болон эдийн засгийн дотоод зөрчил, сүйрлийн үндсэн дээр бий болсон гэж шинжлэх ухаан бүхэлд нь тайлбарладаг.

Бурханы шашин үүссэн нийгмийн шинж чанар нь бусад шашны нэг адил Фридрих Энгельсийн хэлснээр “Хамгийн анхны эрт вөд өөрсдийн төрөлх чанарын тухай, өөрсдийнхөө орчин тойронд байгаа гадаад байгалийн тухай тэр вейн хүмүүсийн хамгийн харанхуй бүдүүлэг төсөөллөөс шашин үүсчээ. ... Харин түүхийн агуу их эргэлтүүдтэй уялдаатайгаар одоо хүртэл байгаа дэлхий дахины гурван шашин Буддизм, Христос, Лалын шашин бий болжээ.”²

Ийнхүү хүн төрөлхтний нийгмийн түүхийн өрнөл хөгжилт, зөрчил болон үзэл санааны үүсэл хөгжлийн ноёрхогч нийгмийн доторхи нийгэм, түүхийн вө онцлогтой хамт холбоотойгоор үүсэн гардаг номлол учир дорно дахины ард түмний оюун санааны амьдралд гүнзгий үл мөрөө үлдээжээ.

Бурханы шашин нь эртний Энэтхэг орны доторхи нийгэм, улс төрийн түүхэн хөгжлийн явцад үүсэн бий болж, улмаар бусад орнуудад өргөн дэлгэрчээ. Энэтхэгт үүсч хөгжсөн бурханы шашны номлол нь манай тооллын вөөс эхлэн Азийн улс түмний дунд, ялангуяа бурханы шашны дээд хөлгөн ёс нь Төв Азид их дэлгэрсэн байна.

Төвд оронд дэлгэрсэн бурханы шашны үзэл номлол нь дотроо олон урсгалтай төдийгүй нутаг орны буюу сүм хийдийн нэрээр алдаршсан байхад зарим нь бурханы шашны томоохон зүтгэлтний нэрээр нэршжээ. Төвдөд бурханы шашин дэлгэрч номын ёсыг тайлбарлахдаа зарим нь дан ганц доод хөлгөн судрын ёсны сургаал номлолыг түшдэг бол нөгөө нь дээд очир хөлгөн тарнийн ёсыг даган баримтлах бус эсвэл хоёр урсгалын үзэл санааг хослох чиг шугамыг баримталдаг ёсон байжээ. Төвдөд бурханы шашны Сажавагийн, Гажудвагийн, Очир хөлгөний ёс гэх зэрэг хэд хэдэн урсгал хэлбэрээр дэлгэрчээ.

Эдгээрээс Гаадамбын салбар нь 1X зууны II хагаст Төвд оронд үүссэн бөгөөд түүнийг дэлгэрүүлэн хөгжүүлэхэд Энэтхэгээс залагдан ирсэн лам Зава Адши (982-1054) асар их нөлөө үзүүлжээ.

Адши, зөвхөн бурханы шашны үзэл сурталыг дэлгэрүүлсэн төдийгүй сүм хийдийн амьдралыг зохион байгуулах, бурханы шашны ёс дэглэм, хурал номын ёсыг тогтоон хэрэгжүүлэхэд их үүрэг гүйцэтгэжээ.

XI зууны вөд Төвдөд бурханы шашны доторх олон урсгал дотроос улаан малгайтны шашин зонхилж байв. Өөрөөр хэлбэл, Сакъяа буюу улаан малгайтны шашны урсгалыг номлогчдын сүм хийдийн томоохон феодалууд барьж байсан учраас засгийн эрхийг угсаа залгамжлан барьж өөрийн ноёрхолыг 1092-1128 онуудад тогтоож байжээ. Гэвч тухайн вөд Төвдэд улс төрийн хямрал гүнзгийрч, эрх мэдлээ алдах аюул заналд учирсан вөд Улаан малгайтнуудын вө залгамжлагч Пагва лам хэмээх Лодойжалцан (1235-1280) Монголын хаанаас тусламж гуйсан юм. Монголын их хаан Хубилай 1268 онд Пагва ламыг Төвдийн засгийн толгойлогч болохыг зөвшөөрч хөрш гурван орны номын хаан цол шагнажээ. Пагва ламын явуулж байсан бодлого үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн нь Төв Азид, ялангуяа Монгол оронд шашин дэлгэрэх үүд хаалгыг нээж өгсөн байна.

Чухам тэр вөд Төвд оронд засгийн эрхийн төлөө хар, шар феодалуудын тэмцэл хүчтэй өрнөж, улааны шашны нөлөө буурч эхэлсэн төдийгүй түүнийг идэвхтэй дэмжиж байсан Монголын их хаадын төр сулармагц Монгол дахь нөлөөгөө алджээ.

Харин ХҮI зууны сүүл вөөс улааны шашин өөрийн нөлөөг бүр мөсөн алдаж, түүний байранд шар малгайтны шашин хүчтэй болж хөгжив. Бурханы

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

шашны энэхүү урсгал нь түүхэнд шарын шашин хэмээх нэрээр алдаршжээ. Нөгөө талаар Адшигийн үндсийг Гаадамбын урсгал ялсан нь шар малгайтны шашны урсгалд асар их нөлөө үзүүлсэн төдий ч шинэ Гаадамбын салбар гэж нэрлэх ч явдал байдаг.

Зава Адшигийн дараа Төвд оронд дэлгэрсэн бурханы шашны энэхүү урсгалыг тухайн үеийн нийгэм, эдийн засгийн байдалд зохицуулан шинэчлэл хийсэн хүн бол бурханы шашны түүхэнд Шарын шашны эзэн хэмээн алдаршсан Зонховлувсандагва /1357-1419/ гэгч хүн билээ.

Зонхов нь Төвд дэх түүхийн тодорхой нөхцөлийн дотор дэлгэрч байсан бурханы нэг шашны ёс номлолыг гүнзгийрүүлэхэд хичтэй нөлөө үзүүлсэн төдийгүй түүний номлол ёсыг Төвд орны тухайн нөхцөл, хүн ардын оюун санаанд тохируулан хэрэглэсэн нь нэр алдрыг нь шүтүүлэн олны дотор улам алдаршуулахад хүргэлээ.

Төвдийн бурханы шашны нэрт төлөөлөгч Зонхов бурханы шашныг дундад зууны үеийн байдалд зохицуулан сэргээж шинэтгэсний хувьд түүний туурвисан бүтээлүүд зөвхөн Төвд оронд төдийгүй Төв Азийн дунд олон түмний оюун санааг шарын шашны үзэл санаа, номлол, ёс дэглэмээр эзэмдүүлэхэд үзэл онолын чухал үндэс суурь нь болж иржээ. Зонхов Төвдөөс бурханы шашны гол урсгал шарын шашныг үндэслээд, шашны бусад урсгалуудаас ялган, түүний бие даасан шинж чанартай болгожээ. Гэхдээ энэ нь бурханы шашнаас шарын шашныг салгалаа гэсэн хэрэг биш харин түүний ёс үндэслэлийг хатуу баримталжээ. Шарын шашны ертөнцийг үзэх үзлийн тогтолцоо нь бурханы шашны судрын ба дондорын /тарни/ хэмээн хоёр томхон чиглэлийг хослон баримтлах үзэл дээр төвлөрч байсан юм.

Зонхов бурханы шашны доод дээд хоёр хөлгөний аль нэгийг эсвэл нэгийг нөгөөгийн эсрэг тавих замаар биш, харин тэдгээр хоёр ёсыг хослон баримталж, түүнд заасан номлол сургаалыг даган бишрэх замаар хүлээн авсан нь номлолын хувьд бусад урсгалаас ялгагдсан хэрэг мөн болно.

Зонхов Богдын хийсэн нэг чухал шинэчлэлт бол бурханы шашны номлолын үндэс болох арга билгийг шүтлэгтэн олонд амар хялбар ухамсарлуулах зорилгоор дээд хөлгөний ёсонд өргөн томъёологдсон лам хувраг хүний үүргийг улам өндөржүүлж, багш шавийн барилдлагат ёс журмыг тогтоосон нь шарын шашин олон түмний дунд түгэн дэлгэрэх нэг үндэслэл болжээ.

Зонхов бурханы шашинд хийсэн шинэчлэлийн гол үзэл санаа нь:

"- Бурханы шашны дээд, доод хөлгөн ёсыг салгалгүй хослон барих,

- Энэхүү номлол сургаалыг эзэмшсэндээ гагцхүү бурханы шашны ёсон дахь арга билэг, /онол, программ/ хоёрыг тууштай харуулах,

- Лам хувраг түүний ролийг дээшлүүлэх замаар багш шавийн барилдлагыг тогтоох,

- Шашны ёсонд суралцах аргыг нэлээд нарийвчлан дэс дараалалтай гүнзгийрүүлж өгсөн явдал мөн."³

Богд Зонхов ийнхүү бурханы шашны номлол, түүнд суралцах аргыг хатуу даган, өөрийн шар малгайтны урсгалыг бэхжүүлэхийн тулд үзэл санаа, зохион байгуулалтын хувьд шинэтгэл, өөрчлөлт хийж, түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд хүчин зүтгэж байснаараа бурханы шашныг Төвд оронд дахин сэргээсэн юм.

Зонхов Богдын үндэслэсэн шарын шашны салбар XIY зууны эцсээс Төвдөд эрчимтэй хөгжиж улмаар цаашид XYI - XYII зууны вед Төв Азийн улс орнууд, ялангуяа Монголд өргөн дэлгэрчээ.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Монгол оронд бурхантны шашин нилээд эрт цагаас эхлэн нэвтэрч байсан боловч олонхи эрдэмтэд судлаачдын судалгаанаас үзэхэд эхэн үедээ өргөн олныг хамарч чадаагүй юм. Монголын феодалын нэгдсэн төвлөрсөн улс байгуулагдахын өмнө монголын олон аймгууд өөрийн хөрш зэргэлдээ оршиж байсан бусад олон аймгийн нэгэн адил бурханы шашныг зохих хэмжээгээр хүлээн авч байв.

Харин Монголын феодалын тулгар төр тогтож ирмэгц, Монголын их хаадуудад бөөгийн шашнаас илүү үзэл суртлын зэвсэг хэрэгтэй байсан учраас бурханы шашныг аль болох хөхүүлэн дэмжицгээж байжээ. Тухайлбал, Монголын феодалын нэгдмэл төр, феодалын нийгмийг хамгаалан бэхжүүлэхэд чиглэгдэж, гол шүтээн бүхий шашинтай болохыг эзэн Богд Чингис болон түүний хүү Өгөдэй, ач нар Мөнх, Хубилай зэрэг хаадын үеэс эхлэн эрэн хайж эхэлсэн билээ.

Харин энд тэмдэглэж хэлэхэд Монгол гүрний үед дэлхийн гурван том шашны аль аль нь нэвтэрч эхэлсэн боловч тус гүрний хаад чухамхүү бурханы шашныг тэтгэн дэмжин залж, төрийнхөө шашин мөргөл болгосон юм. Үүний учир шалтгаан нь:

1. Монголчууд маш эрт цагаас эхлэн Энэтхэгийн шашин ба соёлын өв уламжлалтай шууд буюу тойруу замаар танилцсан төдийгүй түүнийг үе үе хүлээн авч байсан түүхэн залгамж холбооны нөлөө туссан.

2. Монгол нь бурханы шашин эрт дэлгэрсэн Төвд оронтой ойр залгаа нутаглаж байсны дээр түүнийг ХШ зууны үед эрхшээлдээ оруулсан явдалтай холбоотой.

3. Шашин төр хоёрыг заавал хослон барилдуулах тухай бурханы сургаал дахь хоёр ёс хэмээн нэг гол үзэл санааг монголын язгууртан ноёдод нэн таалагдсан юм.

4. Бурханы шашин нь ихээхэн энэрэнгүй, нигүүлсэнгүй, хүн ардын тусын тулд байдаг зэргээс шалтгаалсан болов уу гэж үзэх үндэстэй билээ.

Ялангуяа Хубилай хаан бүр 1260-аад онд Бурханы шашны Сакья салбарын тэргүүн Пагва ламыг урин залж, улмаар Бурханы шашныг нийт гүрний албан ёсны гол шашин мөргөл болгохоор шийдвэрлэжээ. Тэгээд ч Хубилай хаан улсын их багшийн тамгыг Пагва ламд өргөн барьж, түүнийг Монгол их гүрний шашны тэргүүнээр өргөмжилжээ. Пагва лам, Хубилай хааны ордонд олон жил суухдаа бурханы шашныг Монголын язгууртны дунд дэлгэрүүлэн, түүнийг феодалын төр, түүний ангийн ашиг сонирхолыг хамгаалах зэвсэг болгон хувиргахын төлөө ихээхэн чармайжээ.

Пагва лам хэмээх Лодойжалцан нь "Төр ба номын хоёр ёсон буюу төр шашныг хослон барих тухай эртний Энэтхэгийн Бурханы шашны гол үзэл санааг Монголын феодалуудаас шашны хувьд эрхэмлэн дээдэлж төрийн бодлого болгон дэвшүүлжээ."⁴ Үүгээрээ Пагва лам феодал ангийн төр нь гагцхүү буддын шашныг түшин шүтэх үндсэн дээр оршин байх тухай үзэл ёсыг Юан гүрний язгууртны дотор гүн нэвтрүүлэхийн хамт тэдний дэмжлэгтэйгээр төвд дэх Бурханы шашны олон салбарын зөрчил хямралыг зөөлрүүлэн, түүнийг Монгол, Хятад оронд дэлгэрүүлэх алсын зорилтыг тавьж байжээ. Пагва лам нь Монголд Бурханы шашныг дэлгэрүүлэхийн тулд олон тооны захидал, сургаал зэрэг ном судар бичихийн хамт хааны даалгавраар 1269 онд Дөрвөлжин бичиг зохиожээ.

Ийнхүү Хубилай хаан өөр нэг шашныг бус харин гагцхүү бурханы шашныг их гүрний албан ёсны гол шашин мөргөл болгож авсны зорилго нь юуны өмнө эзлэгдсэн олон аймаг, угсаатныг төрийн нэгэн шашны үзэл санаагаар гагнан барилдуулах замаар ноёрхолоо бэхжүүлэхэд оршино.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Нөгөө талаар Юан гүрний хаад нь Бурханы шашныг бас цөөн тоотой Монголчуудыг Хятадын күнзийн суртлын хвчтэй нөлөөг эсэргүүцэн зогсоох үзэл суртлыг зэвсэг болгон ашиглах зорилгыг агуулжээ.

Хубилай хааны энэ бодлогыг дараа дараагийн хаад үргэлжлүүлэн гол төлөв Сакия хийдийн эрх баригч томоохон лам нарыг гүрний нийслэлд удаа дараалан залж шүтэж байв. Хубилайн залгамжлагчид Пагва ламын дараа Сакиягийн лам Дармабал, Чойжи Одсэр, Гармаагийн салбарын Рянжундорж, Ролбидорж эрэг лам нарыг удаа дараа залж тэдэнд улсын багш уламжлалт цол олгож байв.

XIV зууны вед нэрт орчуулагч Чойжи Одсэр 1305 онд Бодигаръявадаръя, 1308 онд Банзрагч орчуулагч Шаравсэнгэ, Алтангэрэл бурханы 12 зохионгуй зэрэг голдуу шашны агуулгатай зохиолуудыг монгол хэлээр орчуулсан явдал нь монгол оронд бурханы шашин нэвтрэхэд багагүй нөлөө үзүүлжээ.

Ийнхүү Бурханы шашин Монгол гүрний вед үлэмжхэн нөлөөтэй болж, эртний бөө мөргөлийн байр суурийг хвчтэй бууруулжээ. Бурханы шашин нь зөвхөн язгууртнаар зогсохгүй, нийт хүн ардын дотор ч аль нэг хэмжээгээр нэвтэрчээ.

Гэвч XIII-XV зууны 70-аад он хүртэл Бурханы шашин нийт Монголчуудын ахуйд гүнзгий нэвтэрч тэдний оюун санааг бүрнээ эзэмдэж чадаагүй тул дурдсан вед тус оронд хуучин хэвээр бөө мөргөл зонхилсоор байжээ.

Энэ тухай саган Сэцэний Эрдэнийн товчид “Хубилай хаан....Пагва лам хоёр тэргүүлэн монголын номын хаад Сакия шидтэн лам нартай учирч, хоёр төрөөр (шашин, төр) хотол амьтныг үлэмж жаргалантай болгосон ажгуу. Түүний хойно ухаант Сэцэн (Тогоонтөмөр) хаанаас янагш шашин-төр хоёр өчүүхэн цувлдэснээр (эзгүйдсэнээр) вйл дор нүгэл хилэнцийг вйлдэж, идхүй нь мах, цусаар эдлэн амуй биед нь”⁵ гэж өгүүлсэн байдаг.

Ийнхүү XIV зууны дунд үеэс XVI зууны сүүлч хүртэл монголчууд Бурханы шашныг гоц анхаарахгүй харин хуучин бөө мөргөлийг голчлон анхаарч түүнийг шүтэн бишрэх явдал улам өргөн олныг хамрах хандлагатай болжээ. Ийнхүү монгол гүрний вед бурханы шашныг бүх талаар дэмжин тэтгэж байсан боловч улс орны зонхилох шашин мөргөл болж чадаагүй явдал нь дараах объектив, субъектив хвчин зүйлүүдээс шалтгаалсан билээ. Үүнд:

- Хубилай хаан, уул шашныг албан ёсны шашин мөргөл болгож тунхагласан боловч, түүнийг Бээжин, Ханбилэг, Лань-Чжоу зэрэг хотын их язгууртны дунд тэргүүлж, нийт монголчуудад хвчээр тулгаж шүтүүлээгүйтэй шууд холбоотой.

- Монгол гүрний төр-шашин ба соёлын төв нь эх нутагтаа бус, харь Хятад оронд оршиж байсан.

- Феодалын төр, сүм хийдийн зүгээс XVI-XVII зууны үеийнх шиг Бурханы шашны номлол, зан вйл сургаалыг нийт Монголчуудын дунд өргөнөөр сурталчлан, хуучин бөө мөргөлөө орхигчдод материаллаг урамшуулал үзүүлээгүйтэй шууд холбоотой юм.

Гэвч энэхүү Бурханы шашин Монгол оронд нөлөөгөө алдаж унах хандлагатай байсан нь түр зуурын үзэгдэл болсон юм. Харин XVI зууны эхэн үеэс бурханы шашин, шарын шашны хэлбэрээр хвчирхэг дэлгэрч, нийт Монголчуудын оюун санааг эзэмдсэн билээ.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Ийнхүү Монголд шарын шашин дэлгэрүүлэх явдал нь тус оронд олон жил үргэлжилсэн феодалын бутралыг даван туулж, улс төрийн талаар нэгтгэх, шарын шашны үзэл санаагаар монголчуудыг оюун санааны хувьд нэгтгэх зорилготой уялдан гарснаар түүхэн ач холбогдолтой үзэгдэл болж байгаа юм. Ийм учраас монголын нөлөө бүхий феодалууд шарын шашныг шүтэн биширч дэлгэрүүлэх талаар бүх хүчээ дайчлах болов. Монголын феодалуудын дотроос Юан улсын дараа шарын шашныг өөрийн эрх нөлөөг бататган бэхжүүлэх зорилгоор дэлгэрүүлсэн томоохон феодалууд бол Түмдийн Алтан хаан (1507-1582), Цахарын түмэн засагт хаан (1558-1593), Халхын Абтай (1554-1588), Ойрадын Хар хул зэрэг хүмүүс юм. Тэд нар бараг ойролцоо цаг үед шарын шашныг өөрсдийн нутагт дэлгэрүүлэх бодлогыг идэвхтэй явуулж байв.

Анх 1577 онд Алтан хаан далай лам Содномжамцыг (1542-1588) Хөх нуурын Чавлаан газар хүндэтгэн залж, өөрөө эхлэн бусад Ордосын феодалуудыг шарын шашинд оруулсан байна.

Монголын феодалуудын дотроос хамгийн хүчирхэг Түмдийн Алтан хаан ийнхүү шарын шашны тусламжтайгаар нийт монголыг өөрийн эзэмшилд оруулан нэгтгэн захирах бодлогыг тууштай явуулж байсан нь харагдаж байна.

Энэ нь Алтан хаан, Содномжамц лам хоёр өөрсдийн биеийг Хубилай, Пагва лам нарын шашин төрийг хослуулан хөгжүүлсэн их хэргийг цаашид үргэлжлүүлэгчид гэж үзэж байсантай шууд холбоотой юм.

Бөө мөргөлийг орхин, шинэ шарын шашныг авахтай холбогдуулан хийсэн ёслол дээр Алтан хаан, Содномжамцыг бүх шарын шашны толгойлогч хэмэн өргөмжилж, түүнд Далай лам гэдэг цолыг өргөмжилсөн төдийгүй, бас Содномжамц нь Алтан хаанд Хубилай хааны анхны цолыг хэрэглэхийг зөвшөөрч, шашны тухай тусгай хууль гаргахаар болжээ. Түүнийг Ордосын Сэцэн хун тайж зохиохдоо Хубилайн Арван буянт номын цагаан түүхийг өргөн ашигласны хамт ураг төрлийн байгууллын үед үүссэн бөөгийн мөргөлийн зарим нэг зан үйлийг шууд үгүйсгэж арван цагаан буяныг дэлгэрүүлж шүтэх хууль цаазыг боловсруулжээ. Тус цаазад:

- үхэгсдийг оршуулахад тэмээ, морийг алж хойллог хийхийг зогсоох

- жил ба сар тутам малын амь таслахыг тэвчин мацагийн санваар барих

- Цоржийг хунтайжтай, Рабжамбагавжийг тайж нартай, гэлэнг тавнан ханжинтай, тайж шимнац (чавганц) убаши, убасанд нарыг онлигууд (бага тайж) нартай адил эрхтэй болгох. Хэрэв тэдэнд энгийн ард гар хүрэх, хараах, үг хэлээр дайрвал хун тайж нарыг зансантай адилхан шийтгэх

- Лам нар номын есыг зөрчиж гэргий авбал сүм хийдээс хөөх, убаши, убасанд нар амьтныг нядалбал сахилын авч хар болгох, тойон, убаши нар архи дарс уувал хамаг юмсыг хайж авах”⁶ гэх зэрэг зүйлийг заасан байна.

Алтан хаан, Содномжамц ламтай хэлэлцээр байгуулж, шашны цааз тогтоосон нь юуны өмнө өөрсдийн эрх мэдлийг бататгаад зогсоогүй, тухайн үедээ зургаан түмнийг товчилсон төв засгийн газар байгуулан, Монголыг захирч байсан Түмэн засагт хааны эсрэг чиглэгдэж байв. Өөрөөр хэлбэл Алтан хаан Төвдийн нөлөө бүхий Содномжамц ламын дэмжлэгтэйгээр биеэ Хубилай хааны үйл хэргийг үргэлжлүүлэгч бүх Монголын хаан хэмээн нийтэд зөвшөөрүүлэн хүлээлгэх зорилго тавьж байв.

Алтан хааны нас барсны дараа Баруун Түмний байдал аажмаар доройтож нөлөө бүхий хаад бараг үгүй болсон тул Далайлам, зүүн гурван түмний томоохон феодалууд тухайлбал, тухайн үед ихээхэн нөлөө бүхий

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

хвчирхэг Түмэн засагт хаантай холбоо тогтоох бодлогыг тууштай явуулж эхлэв. "Харин Түмэн засагт хаан, Алтан хаантай монголд шашин дэлгэрүүлэх талаар өрсөлдөж, бүр 1576 онд Төвдээс илд зангидагч улаан малгайтны шашны лам Гармаа гэгчийг урин авчирч түүнтэй багш шавийн барилдлагаа тогтоож шашинд орж улсын дотор шашныг дэлгэрүүлэх ажлыг зохиосон байжээ." ⁷ Энэ баримтаас үзэхэд Алтанхан, Түмэн засагт хан нар шашныг Монгол оронд дэлгэрүүлэх талаар харилцан бие биеэс өрсөлдөж байсныг харуулж байгаа юм.

Харин 1V далай лам Ендонжамцыг /1588-1616/ Төвдээс биш, харин монголын том феодал алтан хааны ач хvв Сэнгэдvүрэнгийн гэр бүлээс тодруулсан явдал ч санамсаргvй бус болов уу. Энэ нь Төвдийн том шар феодалууд шарын шашныг монголчуудын дунд улам гvнзгий дэлгэрvүлэхийн хамт ирээдvйд тэднийг хvчээр дотоодынхоо дайсныг номхотгон хазаарлахын тулд Ш далай лам Содномжамц нас нөхцөхийн өмнө Монголд төрнө гэж хэлсэн хэмээх домог яриа саяхан болтол Төвдчvүдийн дунд уламжлагдаж иржээ.

1V далай лам 1604 оноос эхлэн харь орон Төвдэд сууснаас гадна бага насалсан хэдий боловч Лхасаас монголд тусгай лам илгээх зэргээр шарын шашныг монголд түгээн дэлгэрvүлэхэд асар их vүрэг гvйцэтгэжээ.

Ийнхvв Түмэдийн феодалууд өөрсдийн дундаас Төвдийн толгойлогчийг тодруулсан явдал нь тvүнийг ашиглан Төвдийг эрхэндээ оруулан, улмаар бvх монголыг нэгтгэх зорилтыг тавьж байсан боловч vр дvнд хvрээгvй юм.

Алтан хан шарын шашныг хvлээн авч дэлгэрvүлсний дараагаар монголын феодалууд дагалдан дууриаж эхэлсэн юм. Халхын Абтай /1554-1588/ Түмэдийн Алтан хан шарын шашинд орж нэр алдар ихээхэн дэлгэрч байгааг сонсоод, 1577 онд өөрийн биеэр Хөх хотод ирж далай лам Содномжамцтай учирч шашныг халхад дэлгэрvүлэхээр харилцан тохиролцоод зогсоогvй III Далай лам халхын феодалуудын дотроос анх удаа Абтайд Очир бат тvшээт хан цолыг олгожээ.

Абтай хан монгол оронд /халхад/ шарын шашныг дэлгэрvүлэх талаар уйгагvй зvтгэсний хvчинд тvүний нэр хvнд нэмэгдэж улмаар бvх халхыг дангаар захирах байдалтай болжээ. Абтай хан Төвдийн далай ламын шууд дэмжлэгтэйгээр 1585-1586 онд тус орон дахь шарын шашны анхны сvм хийд Эрдэнэзууг эхлэн байгуулжээ. Ийнхvв Абтай хан III Далай ламын төлөөлөгч Ширээт Гvүшцоржийн шууд оролцоо тусламжтайгаар халх-монгол дахь хуучин бөө мөргөлийг хvчээр хавчин арилгах тухай албан ёсоор тунхаглан шарын шашныг төрийн шашин мөргөл болгожээ.

Ялангуяа халхын хамгийн нөлөө бvхий том феодал Тvшээт хан Гомбодоржийн хvв Занабазарыг 1639 онд дарнатын хувилгаан, шарын шашны тэргvүнд өргөмжлөгдсөн явдал нь санамсаргvй зvйл биш юм. Энэ нь шарын шашныг тус оронд дангаар нь төгс ноёрхуулан, нэгдмэл удирдлага бvхий төвлөрсөн сvм хийд байгуулах замаар халхын улс төр, vзэл суртлын хувьд нэгтгэн бэхжvүлэх гэсэн том феодалуудын зэрэгцээ тvүнийг дэмжигч Төвдийн далай лам, Банчин Эрдэнэ нарын бодлоготой зvйл болжээ.

XVI зууны сvүл хагаст Төвд дэх бурханы шашны олон салбаруудын хооронд явагдсан тэмцлийн эцэст шар малгайтны салбар тус оронд зонхилох болсноор IV-V далай лам, I Банчин богд нар монголд ч гагцхvв шарын шашныг бүрэн ноёрхуулах бодлогыг явуулж эхэлсэн юм. Хэрэв монголын феодалууд шарын шашны тусламжтайгаар феодалын дотоод хямралыг зогсоож монгол туургатныг улс төрийн талаар нэгтгэх бодлого явуулж байсан бол Мин улс чухамхvв шарын шашны vзэл санаагаар хөрш орнуудыг номхатган захирах найдвартай зэвсэг болгон ашиглахыг оролдож байсан боловч төдийлөн vр дvнд хvрээгvй юм.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Монгол оронд шарын шашныг дэлгэрүүлэхэд өндөр гэгээн Занабазар нь асар их үүрэг гүйцэтгэсэн билээ. Өндөр гэгээн нь Төвд оронд олон жил шашны дамжаанд суралцаж 1651 онд Монгол нутагтаа буцан ирмэгц үнэхээр шарын шашныг дэлгэрүүлэх, хүрээ хийд байгуулах, шашны ном сургаалыг орчуулах, бурханы зан үйл, үзэл санааг зонхилуулахад онцгой анхаарсан зүтгэлтэн билээ.

Занабазар нь бусад шашны зүтгэлтэн нарын хамт олон арван бурхан цутгасны дотор өөрийн гараар Важидор хэмээх 8 суварга бүтээж, Төвдээс Ганжуур данжуурын бүрэн ботийг худалдан авахын зэрэгцээ чухамхvv энэ үед Занабазарын урлаг гэж нэрлэгдсэн дорно дахины гайхамшигт уран хийцтэй цутгамал Дарь эхvvдийг бүтээжээ. Үүнээс гадна гахай жил /1657/ Занабазарыг Эрдэнэзууд урин залж шарын шашны их ерөөл хуруулан, Майдар эргүүлэх арван догшид ба ганшуудыг тус хийдийн тогтмол жасаа хурал болгож уншуулахаар тогтсон билээ. Энэ нь хэрэг дээрээ уул хийдэд улбаалсаар байсан Сакия /улаан/-ын ёсыг шарын шашныхаар үндсэнд нь халж өөрчилсөн нь харагдаж байгаа юм.

Энэ тухай "Монгол дахь буддын шашны тvvх хэмээх сурвалжид Гэгээний 23 насан дээр гахай жил /1657/ дор Эрдэнэзууд халхын ноёд бат оршил өргөж, их ерөөл хурж тэндээс уламжлалаар олон орнуудад номлох бүтээхийн олон хийд хүрээг байгуулж, шашин эрднийг арвитган дэлгэрүүлбэй" ⁸ гэж өгүүлжээ.

Занабазарын халхад шарын шашныг дэлгэрүүлэх идэвхитэй үйл ажиллагаа нь Халх-ойродын самууны үед /1688-1697/ үед нэлээд саатсан боловч 1698 оны үеэс эхлэн шашны үйл ажиллагааг дахин сэргээж, улмаар барс жилд /1698/ Сэцэн хан аймагт ирж далай ламын намтар Төвдийн Сандаг хэмээх толь бичгийг монгол хэлэн дээр орчуулалцахын хамт соёмбо үсгийг зохиожээ.

Тvvнчлэн Занабазарын хамт шарын шашинг эрчимтэй дэлгэрүүлсэн хvmvvсийн тоонд Сайн ноён хан аймгийн Зая Бандида хутагт Лувсанпэрэнлэй /1642-1715/, Эрдэнэбандид хутагт Лувсанданзан-Чойжилжалцан /1639-1704/ нарыг нэрлэж болох юм. Тэд нар Төвдэд шашны эрдэмд суралцсаны дараа эх Монгол нутагтаа ирж, шашны номлолыг дэлгэрүүлэхэд үлэмжхэн үүрэг гүйцэтгэжээ. Тухайлбал Лувсанпэрэнлэй, шашны холбогдолтой олон ном туурвисны дотор Болор толь хэмээх Энэтхэг Тvvд, Монголын Бурханы шашны тvvхийн 4 боть, Хуврага Лувсанпэрэнлэйгийн хорвоогийн үйл явдлыг өгүүлсэн их ёс гэрэлт зул хэмээх нэртэй өөрийн товч намтар зэрэг бүтээлийг бичжээ.

Тvvнчлэн Эрдэнэбандида хутагтын анхдугаар хувилгаан Лувсанданзан-Чойжилжалцан нь Халх Монголд олон арван сvm дуган хийд байгуулж, тэнд шарын шашны номлол үзэл санааг дэлгэрүүлсэн нь сvsэгтэн олонд алдаршжээ. Энэ тухай сурвалж бичигт "Богд лам /1 эрдэнэбандида хутагт/ бас хошуу тус бүрт шинээр дацан сvm байгуулах тухай халхын бусад ноёдод зарлиг буулгаж шашныг халхад мандуулав" ⁹ гэжээ. Шарын шашин нь зөвхөн Төвд, халх монголд төдийгvi, Ойрадад бараг нэгэн цаг үед дэлгэрч зонхилсон бөгөөд зарим үед Ойрадын нөлөө бүхий лам хуврагууд халхад шарын шашны цаашид дэлгэрэлтэнд ч нөлөө үзүүлжээ.

Ойрадууд шарын шашныг анхандаа өмнөд Монголоор дамжуулан авч улмаар XVI-XVII зууны зааг үед баруун монголын зонхилох шашин мөргөл болон хувирчээ. Ойрадад шарын шашныг анх дэлгэрүүлэхэд тус орны томоохон феодал Сайн тэнгис мэргэн Тэвинэ /Аюуш хан/, Байбагас хан нар онцгой үүрэг гүйцэтгэжээ. Судлаачид 1616 оны үед Ойрадууд шарын шашныг албан ёсоор төрийн шашин мөргөл болгон тунхагласан гэж үздэг бөгөөд шашныг өргөн хэмжээгээр дэлгэрүүлэхэд Зая Бандид Намхайжамц /1599-1662/ асар их үүрэг гүйцэтгэсэн билээ.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Ялангуяа Зая Бандида нь Ойрадад олон арван сүм дуган байгуулж, Мань галбум, Малын намтар, Молом тойны намтар мэт шашны ном судар түүх гүн ухаан уран зохиол анагаах ухаан, зурхай зэрэг олон ном зохиолыг орчуулах, бичих замаар тус оронд шарын шашныг дэлгэрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Ингэж Зая Бандида бурханы шашны номлолыг зүйл бүрээр тэтгэн дэмжиж, Ойрад Монголд дэлгэрүүлэхийн хамт бөө мөргөлийг хавчин зайлуулах бодлогыг хвчтэй явуулсан билээ. Баруун Монголд XVII зууны үед шарын шашин эрчимтэй дэлгэрч сүм хийд байгуулагдан, лам нарын тоо олширч буддагийн шашны сургууль байгуулагджээ.

Сурвалжаас үзэхэд, XVII зууны эхэн хагаст Булнай, Дайчин хошуугийн суврага, Эргис, Бороо талын сүм, Зая бандидын хувийн сүм зэрэг нүүдлийн ба хувийн олон сүм дуганууд байгуулагджээ¹⁰.

Түүнчлэн Эрдэнэбаатар хунтайж, Галдан бошигт, Цовээнравдан зэрэг хааны үед ч Ойрадад олон тооны сүм дуган байгуулагдаж, тэдгээр хаадаас сүм хийдийг ч бэхжүүлэх шарын шашны номлолыг дэлгэрүүлэх талаар онцгой анхаарч ирснийг тэмдэглэх нь чухал юм. Ийнхүү шарын шашин нь XVI зууны эцэс, XVII зууны эхний хагаст бүх халх, Ойрад Монголд бүрэн ноёрхож эхэлсэн учир 1640 оны Монгол-Ойрадын хууль хэмээх нэгдмэл цааз бичгээр нийт монгол угсаатны төрийн шашин мөргөл болгон тунхаглаж, шарын шашны сүм хийд, дээд лам нарт дахин онцгой эрх дарх олгожээ. Ийнхүү Монгол оронд шарын шашин харьцангуй богино хугацаанд бүх нийтийн оюун бодлыг өөртөө татагч үзэл санааны том хвчин зүйл болж чадсан нь дараах объектив, субъектив зүйлтэй шууд холбоотой юм. Энэ нь:

1. Шарын шашныг ноёрхогч ангиас ард олонд тусган хүлээлгэснээс гадна, түүний үзэл номлол, зан үйл нь сүсэгтэн олны талархлыг хүлээж байсантай шууд холбоотой юм.

2. Шарын шашныг феодалууд эрчимтэй дэмжиж, хошуу нутаг бүрт нүүдэлчин ардын ахуй амьдралд зохицуулсан олон тооны гэр дуган барихын хамт айл өрх бүрд шүтээн онгодын оронд бурхан сахиус тавиулах болжээ.

3. Бурханд зориулсан жасаа, даллага вйлдүүлж, хүн бүрээр маань мэгзэм уншуулж, хүрд эргүүлэх зэргээр шинэ шашны зан үйлийг хүмүүсийн ахуйд хвчтэй нэвтрүүлж, сүүлдээ олон сүм дуган байгуулан, тэнд гүн ухаан, анагаах ухаан, зурхай зэрэг номын дацан, сургуулиуд бий болж, олон лам нарыг байнга шавилан суулгах зэргээр сүсэгтэнд вйлчлүүлжээ.

4. Лам нар нь эртний Энэтхэг, Төвдийн анагаах ухаан зурхай зэрэг мэдлэг ухааны зарим зүйл болон галбийн аргыг ашиглан сүсэгтэн олныг биедээ татаж, улмаар бурханы шашны гол сургаал Үйлийн үрийн тухай ухагдахууныг Жаргалан сугавади орон ба талын зовлон гэгчтэй холбон янз бүрийн хялбарчилсан аргаар ард түмний дунд өргөнөөр номлож гийгүүлсэн юм.

5. Төвдийн Далай лам, Банчин-Эрдэнэ нар Монголд шарын шашныг дэлгэрүүлэхийн тулд олны дотор амьд бурхан хэмээн нэрлэгдсэн хутагт хувилгаадыг тодруулан, тэднийг зориуд Монголд илгээж байсан нь шарын шашны үзэл санаа ард олныг эзэмдэхэд нөлөөлжээ.

6. Шарын шашин нь Хятад дахь Күнзийн сургаал, Лаозын балбын шашнаас гүн ухааны хувьд хөгжмөл төдийгүй гадаад сүр үзэмж, зан үйлээр бүдүүлэг Монголын бөө мөргөлийг өөртөө харьцангуйгаар хялбар уусган шингээсэн нь шарын шашныг Монгол оронд зонхилоход багагүй нөлөө үзүүлжээ.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Дэлхийн аливаа томоохон шашнууд үүсч хөгжихдөө өөрийн замд тохиолдох ураг төрлийн байгуулалын мөргөлийн хүчээр бүр мөсөн шахан зайлуулахыг эрмэлзэж байжээ. Гэвч тэр нь ганц далайцаар гүйцэтгэж үл болох нарийн төвөгтэй зорилт байсан учир арга буюу хуучин шашин мөргөлтэй аль нэг талаар зохицон нийцэхэд хүрдэг байжээ. Тиймээс ч Төвдийн шашны лам нар нь шинэ хуучин хоёр шашны шүтээнүүд болон тэдгээрийн зан үйлийн зарим нийтлэг зүйлийг ашиглан шарын шашны гол шүтээн зан үйлийг зонхилуулах замаар өөрийн үзэл санааг ноёрхуулсан юм.

Монголын ноёлогч анги ч тус оронд шарын шашныг дэлгэрүүлэхдээ Энэтхэг Төвдийн Бурханы олон үеийн уламжлалт туршлагыг ашиглах зан үйлийг хуучин бөө мөргөлтэй аль нэг талаар зохицуулах замаар түүнийг шарын шашинд уусгах бодлогыг явуулсан билээ. Гэхдээ олон мянган жил ард түмний оюун санааг эзэмдэг ирсэн бөө мөргөл - шашныг уусгах замаар шарын шашныг дэлгэрүүлсэн гэвэл түүхэн үнэнд нийцэхгүй юм. Монголчуудыг оюун санааны талаар хэдэн мянган жил ноёрхсон бөөгийн мөргөл шарын шашинд хавчигдан үгүй болсон явдал нь дараах үндсэн шалтгаантай шууд холбоотой юм. Үүнд:

1. Монголын ноёрхогч феодалууд шарын шашинг дэлгэрүүлэх талаар шургуу тэмцэл хийсэн. Нөгөө талаар бөө мөргөлийн зан үйл хэтэрхий хоцрогдмол, харгис байдлыг ард олон ч, ноёрхогч анги ч ойлгож тухайн үеийн улс төрийн бодлого үйл ажиллагааг явуулахад саад болж байв.

2. Овгийн байгууллын үеийн бөөгийн мөргөл нь феодалын нийгмийн үед аргагүй хоцрогдож, түүхэн хөгжлийн зүй тогтлоор мөхөх шатанд нэгэнт орсон байлаа.

3. Тухайн үед дэлгэрч эхэлсэн шарын шашны үзэл, номлол ёс, зан үйл нь бөөгийн мөргөлөөс илүү дэвшилттэй ард олны зан үйлд ихээхэн ойр дөт байснаас тэд талархан авч байв.

4. Бөөгийн мөргөлийн хоцрогдмол, харгис талыг шарын шашны лам нар аятайхан ашиглаж, хүний энэрэх ёс, амьд амьтнаас цус гаргахын эсрэг, нүгэл хилэнгийн эсрэг 10 цагаан буян, 10 хар нүгэл гэх мэт номлолуудыг тавьжээ. Энэ нь удаан жил тасралтгүй дайн, дотны аюулд учирч дайнгүй энх амгалан, амар түвшин цагийг хүлээн мөрөөдөж байсан Монголын ард олонд амархан итгэгдсэн юм.

Ийнхүү XVI - XVII зууны үед тус оронд шарын шашин дэлгэрч зонхилсон явдал нь феодалын харилцааг бэхжүүлэн Монгол туургатныг улс төрийн хувьд нэгтгэхэд дотоодын эв нэгдлээ бэхжүүлж, дайн дажингүй энх түвшин амьдрахад нийт ард олны оюун санааг нэгдмэл нэг үйл ажиллагаанд төвлөрүүлэн нягтруулахад түүхэн ач холбогдолтой үйл явдал болжээ.

Манай орны судлаачид, түүхчдийн дотор шашны түүхийг тусгайлан судалсан нь ховор төдийгүй, судалсан түүхчид нь их төлөв намч, ангич байр сууринаас хандаж, түүний үзэл санаа, үйл ажиллагааг сөрөг талаас шүүмжлэх зорилтыг агуулж ирсэн.

Тэгвэл өөрчлөлт, шинэчлэлийн өнөө үед шашны түүхийг ялангуяа шарын шашин Монголд дэлгэрч түүний үзэл санаа, хүн ардын оюун санааны үндэс болсныг түүхийн шинжлэх ухааны үүднээс түүхэн үнэн баримт, тухайн цаг үеийн нөхцөл байдалтай нягт холбон судлах нь зөвхөн шашны түүхийн хувьд төдийгүй улс төр, эдийн засаг, соёл зэрэг Монголын түүхийн нилээд асуудлыг нэн зөвөөр үнэлэлт дүгнэлт өгөхөд тэргүүн зэргийн ач холбогдолтой бүс уу.

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

Ишлэл авсан болон ашигласан ном зохиол

1. "В.И.Ленин." - X боть 61,62 талууд
2. К.Маркс., Ф.Энгельс "Тvvвэр зохиол" - III боть УБ 1970. 379,381 талууд
3. Ц. Дамдинсүрэн. "Монголын уран зохиолын дээж 100 билэг оршвой." УБ 1959.
4. "Эрдэнэзуу гэгээний намтар оршвой." УБ 2001 79 тал
5. Саган Сэцэн. "Эрдэнийн товч." УБ 1960 210-212 талууд
6. Саган Сэцэн. "Эрдэнийн товч." УБ 1960 253-254 талууд
7. Саган Сэцэн. "Эрдэнийн товч." УБ 1960 133 тал
8. С. Пүрэвжав. "Монгол дахь шарын шашны хураангуй тvvх." УБ 1978 48 тал
9. Рамжимба Заяа Бандидагийн тууж. УБ 1968 59 тал
10. Бари Дамцагдорж "Лувсанцэвээнжавын намтар." УБ 1960 14 тал
11. "БНМАУ-ын тvvх." I боть УБ 1966
12. "Монголын тvvх" УБ 1999
13. Галдан. "Эрдэнийн эрх." УБ 1960
14. "Асрагч нэртийн тvvх." УБ 1960
15. Ш Нацагдорж. "Халхын тvvх." УБ 1963
16. С. Пүрэвжав. "Хувьсгалын өмнөх их Хүрээ." УБ 1961.